| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 16,800,000.00  | 16,800,000.00  | 0.00           | 100.00% |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 768,000.00     | 768,000.00     | 0.00           | 100.00% |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 768,000.00     | 768,000.00     | 0.00           | 100.00% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 768,000.00     | 768,000.00     | 0.00           | 100.00% |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                       | 323,582,200.00 | 316,987,750.00 | 6,594,450.00   | 97.96%  |
| 31     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ  | 267,431,100.00 | 267,431,100.00 | 0.00           | 100.00% |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих  | 267,431,100.00 | 267,431,100.00 | 0.00           | 100.00% |
| 35     | ТӨСӨВТ БАЙГУУЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНААС                                  | 56,151,100.00  | 49,556,650.00  | 6,594,450.00   | 88.26%  |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 55,651,100.00  | 49,056,650.00  | 6,594,450.00   | 88.15%  |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 500,000.00     | 500,000.00     | 0.00           | 100.00% |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл                    | 0              | 14,766,604.33  | -14,766,604.33 |         |

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт                                       | Төлөвлөгөө     | Гүйцэтгэл      | Зөрүүлэлт     | Хувь    |
|--------|--|----------------|----------------|---------------|---------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН              | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                  | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |
| 2101   | Цалин хөлө болон нэмэгдэл урамшил              | 14,614,300.00  | 14,614,170.85  | 129.15        | 100.00% |
| 210101 | Үндсэн цалин                                   | 11,569,500.00  | 11,569,492.16  | 4417.84       | 100.00% |
| 210102 | Нэмэгдэл                                       | 2,260,500.00   | 2,260,460.14   | 4005.86       | 100.00% |
| 210104 | Урамшуулал                                     | 784,300.00     | 784,318.55     | 81.45         | 99.99%  |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх нийтлэл | 2,038,400.00   | 2,038,308.02   | 91.98         | 100.00% |
| 210201 | Тэтгэрийн даатгал                              | 1,386,100.00   | 1,613,464.91   | -227,364.91   | 116.40% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал                             | 163,100.00     | 118,396.16     | 44,703.84     | 72.59%  |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал                              | 130,500.00     | 94,716.91      | 35,783.09     | 72.58%  |
| 210204 | Ажлын үйлчилгээний даатгал                     | 32,600.00      | 19,248.21      | 13,351.79     | 59.04%  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                          | 326,100.00     | 192,481.83     | 133,618.17    | 59.03%  |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 161,227,400.00 | 126,799,130.03 | 34,428,269.97 | 78.65%  |
| 210301 | Гэрэл, цахилгаан                               | 6,563,700.00   | 5,837,674.03   | 726,025.97    | 88.94%  |
| 210302 | Түшл, халаалт                                  | 148,190,200.00 | 117,587,240.00 | 30,602,960.00 | 79.35%  |
| 210303 | Цэвэр, бохир ус                                | 6,473,500.00   | 3,374,216.00   | 3,099,284.00  | 52.12%  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал              | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00          | 100.00% |
| 210604 | Урсгал засвар                                  | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00          | 100.00% |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                 | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |
| 32     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                 | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |
| 320001 | Орон нутгийн төсвөөс                           | 179,880,100.00 | 145,451,608.90 | 34,428,491.10 | 80.86%  |

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт   | Гүйцэтгэл     |
|--------|--|---------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 10,599,090.00 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | 10,599,090.00 |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 10,599,090.00 |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал   | 3,257,150.00  |
| 210401 | Бичиг хэрэг  | 65,000.00     |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 3,192,150.00  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал  | 720,000.00    |
| 210604 | Урсгал засвар  | 720,000.00    |
| 2108   | Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж   | 1,421,940.00  |
| 210801 | Буслаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 1,421,940.00  |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал  | 5,200,000.00  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал  | 5,200,000.00  |
| I      | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | 10,599,090.00 |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 10,599,090.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,380,000.00  |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 9,219,090.00  |

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Соёлын тухай хуульд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна.

Замын-Үүд сумын Соёл, спортын ордон нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн ил тод хөнгөн шуурхай явуулахын зэрэгцээ нутаг дэвсгэрийн соёл урлагийн үйл ажиллагаанд тулгуурлан сумын Соёл урлагийн үйл ажиллагааг хөгжих нөхцөлийг бүрдүүлэн ажиллах.

Байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт:

- Соёл урлагийн Соёлын биет болон биет бус үйл ажиллагааг бусдад таниулан сурталчлах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Соёлын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Соёл, спортын ордны даргаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.6 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт          |
|---|--------------------|--------------------|-------------------|
| A   | 1                  | 2                  | 3=2-1             |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                  | 14,766.6           | 14,766.6          |
| Авлага  | 6,420.4            | 115.9              | - 6,304.5         |
| Урьдчилгаа  |                    |                    |                   |
| Бараа материал                                    | 35,875.5           | 60,166.7           | 24,291.2          |
| Үндсэн хөрөнгө                                    | 2,882,210.5        | 2,811,847.9        | - 70,362.6        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>2,924,506.4</b> | <b>2,886,897.1</b> | <b>- 37,609.3</b> |
| Өр төлбөр   | 719.3              | -                  | - 719.3           |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 2,923,787.1        | 2,886,897.1        | - 36,890.0        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>2,924,506.4</b> | <b>2,886,897.1</b> | <b>- 37,609.3</b> |

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60.2 сая төгрөг болж 24.39 сая төгрөгөөр өссөн байна. Тодруулбал: Тодруулбал: Спорт заалны засварын ажил болон байгууллагын засварын ажлын материалыг бараа материалаар бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,811.8 сая төгрөг болж 70.3 сая төгрөгөөр буурсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,886.9 сая төгрөг болж 36.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Өр төлбөр байхгүй байна.

Замын-Үүд сумын Соёл, спортын ордны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 73.9 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны орлоготой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 116.1 сая төгрөгөөр буюу 29.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийг орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 161.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 2.0 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 14.6 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.0 сая төгрөг, нийт 179.9 сая төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс нийт 323.6 сая төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 503.5 төгрөгийн төсөв баталснаас 179.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 323.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 447.7 сая төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь цалин хөлс 13.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 34.4 сая төгрөг, хангамж материалын зардал 3.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардал 3.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Д/д      | Хөтөлбөр, арга хэмжээ<br>71702 – Соёл урлаг | Төлөвлөгөө | Гүйцэтгэл  | /мянган төгрөгөөр/ |         |
|----------|---|------------|------------|--------------------|---------|
|          |   |            |            | Зөрүү              | Биелэлт |
| 1        | Үндсэн үйл ажиллагаа                        | 260,663.10 | 260,663.10 | 0.00               | 100.00% |
| 2        | Уран бүтээл хийлгэх                         | 6,000.00   | 6,000.00   | 0.00               | 100.00% |
| 3        | Ажил олгогчоос олгох тэтгэмж                | 768.00     | 768.00     | 0.00               | 100.00% |
| 4        | Дээд шатны төсвөөс хуваарилсан              | 56,151.10  | 34,790.00  | 21,361.10          | 61.96%  |
| 5        | Нийтлэг үйлчилгээ                           | 16,652.70  | 16,652.50  | 0.20               | 100.00% |
| 6        | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал       | 163,227.40 | 128,799.10 | 34,428.30          | 78.91%  |
| Нийт дүн |   | 503,462.30 | 447,672.70 | 55,789.60          | 88.92%  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө 1.4 сая төгрөг. Нийт 10.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Хангамж бараа материалын зардалд 3.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 0.7 сая төгрөг, БГАУТХ зардалд 1.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4.Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төрийн хэмнэлтийн тухай холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 12-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 391.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 406.1 сая төгрөгийн 18 орлогын мөнгөн гүйлгээг хугацаандаа үнэн зөв мэдээлсэн байна. Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 13 шийдвэрийг хугацаандаа үнэн зөв байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 6 эрсдэлийг тодорхойлж, горим сорил хэрэгжүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Хэрэгжүүлсэн тайланг нотлох баримтаар баталгаажуулан ирүүлсэн болно.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |         | Биелэлт |         |      |
|-----------------|------------------------|---------|---------|---------|------|
|                 | Тоо                    | Дүн     | Тоо     | Дүн     | Хувь |
| Акт             |                        |         |         |         |      |
| Албан шаардлага | 5                      | 0       | 5       | 0       | 100  |
| Зөвлөмж         | 3                      | 2,087.3 | 3       | 2,087.3 | 100  |
| Нийт дүн        | 8                      | 2,087.3 | 8       | 2,087.3 | 100  |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.5 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 12.5 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийг нэр төрөл, тоо ширхгээр бүртгээгүйг залруулав.
2. Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийн бүртгэлийг залруулав.

Аудитаар нийт 33.5 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 33.2 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

## **5.1 Төлбөрийн акт**

### **Илрүүлэлт:**

Нэмэгдэл цалин олгох шийдвэргүйгээр 1 албан хаагчид 2 сарын ур чадварын нэмэгдэл 0.3 сая төгрөгийг илүү олгосон байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, зардлыг үндэслэлгүйгээр зарцуулах үр дагавартай байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 382 дугаар тогтоол төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн төлбөрийн акт:**

Илүү олгосон ур чадварын нэмэгдэл 0.3 сая төгрөгийг холбогдох албан хаагчаас буцаан суутгаж, байгууллагыг хохиролгүй болгох

## **5.2 Албан шаардлага**

**1.1 Илрүүлэлт:** Нийт 32.5 сая төгрөгийн 5 ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба гэрээнд заасан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайлан тооцоо хийгээгүй, захиалагчийн өмчлөлд шилжүүлсэн акт бичиг баримт үйлдээгүй, гүйцэтгэгч тал гэрээгээр заасан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн эсэх нь нотлогдоогүй байхад төлбөрийг шилжүүлсэн байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил чанаргүй хийгдэх үр дагавартай байна. Энэ нь Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1-т "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн албан шаардлага:** Бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа, зах зээлийн үнийн судалгаа хийж бага үнийн бодлогыг баримталж, гэрээгээр ажил гүйцэтгүүлэхдээ гэрээний хэрэгжилтийг хангуулж, хийж гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсан акт үйлдэж бүртгэн авч, холбогдох нотлох баримтаар баталгаажуулж ажиллах

**2.1 Илрүүлэлт:** Албан хаагчдын цалингаас нийт 0.6 сая төгрөгийн суутгалыг хууль эрх зүйн үндэслэлгүйгээр суутгасан байгаа нь албан хаагчдад гүйцэтгэсэн ажил хөдөлмөрийн хөлсийг дутуу олгох үр дагавартай байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд хуульд заасан тохиолдолд суутгал хийж болно" гэж заасныг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн албан шаардлага:** Албан хаагчаас илүү суутгасан 0.6 сая төгрөгийг холбогдох ажилтанд нөхөн олгох

**3.1 Илрүүлэлт:** Өмнөх оны зөвлөмжөөр илэрсэн зөрчлийн давтан гаргаж тайлант хугацаанд 73.3 сая төгрөгийн 48 зардлын гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр /и-баримтын системд бүртгүүлээгүй/ хийсэн байна. Тухайн зөрчил нь татварын орлого буруу тайлагнагдах эрсдэл үүсэх үр дагавартай байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**2.2 Өгсөн албан шаардлага:** Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулан ажиллах

## 5.2 Зөвлөмж

### 1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шуудан холбоо, интернэтийн зардлаас нийт 6.6 сая төгрөгийн 2 төрлийн зайлшгүй шаардлагатай бус интернэтийн үйлчилгээг хэт өндөр үнээр авсан, БГАҮТХ зардлаас дахин интернэтийн төхөөрөмж суурилуулах зардал 2.0 сая төгрөг гарсан байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх эрсдэл үүсэх үр дагавартай байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, тус хуулийн 4 дүгээр зүйлд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг баримтлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                        | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                 | Үүнээс     |                 |              |          | Зөвлөмж  |          |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|----------|----------|----------|
|  | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн             | Залруулсан |                 | Залруулаагүй |          | Тоо      | Дүн      |
|  |            |                 |                                   |     |                          |                 | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн      |          |          |
| Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр бүртгээгүй  | 1          | 0               |                                   |     | 1                        | 0               | 1          | 0               | -            | -        | -        | -        |
| Үндсэн хөрөнгийг буруу дансанд бүртгэсэн | 1          | 12,504.0        |                                   |     | 1                        | 12,504.0        | 1          | 12,504.0        | -            | -        | -        | -        |
| <b>Дүн</b>                               | <b>2</b>   | <b>12,504.0</b> |                                   |     | <b>2</b>                 | <b>12,504.0</b> | <b>2</b>   | <b>12,504.0</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                 | Үүнээс        |              |                 |                 |          |          |   |          |
|---|-------------|-----------------|---------------|--------------|-----------------|-----------------|----------|----------|---|----------|
|   |             |                 | Төлбөрийн акт |              | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн |          |
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн          | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      | Тоо                                     | Дүн      |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарчмыг мөрдөж ажиллаагүй             | 1           | 0               |               |              |                 |                 | 1        | 0        | -                                       | -        |
| Цалингийн нэмэгдлийг илүү олгосон                                     | 1           | 352.8           | 1             | 352.8        |                 |                 |          |          |   |          |
| Цалингаас илүү суутгал суутгасан                                      | 1           | 627.2           |               |              | 1               | 627.2           |          |          |   |          |
| Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын үр дүнг хянаагүй, актаар хүлээж аваагүй | 1           | 32,548.0        |               |              | 1               | 32,548.0        |          |          |   |          |
| Өмнөх оны алдаа зөрчлийг давтан гаргасан                              | 1           | 0               |               |              | 1               | 0               |          |          |   |          |
| <b>Дүн</b>  | <b>5</b>    | <b>33,528.0</b> | <b>1</b>      | <b>352.8</b> | <b>3</b>        | <b>33,175.2</b> | <b>1</b> | <b>0</b> | <b>-</b>                                | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Нийт дүн</b>  |             |     |               |     |                 |     |         |     |